



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/23

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймаг дахь салбар “Шунхлай петролиум” ХХК (РД:5512972)-ны хүсэлтийг үндэслэн Мөрөн сум 7 дугаар баг 2 дугаар хэсэгт байрлах 3155м² шатахуун түгээх станцын зориулалтаар эзэмшүүлсэн газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан тул өөрийнх нь хүсэлтийн дагуу 15 жилийн хугацаагаар сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/203 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 3 дахь заалтын 7 дахь баганыг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч “Шунхлай петролиум” ХХК (РД:5512972)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Ганзориг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

